



Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны
Байгууллагын хүрээнд

Сонгуулийн маргааныг шийдвэрлэх нь:

Сонгуулийн маргааныг хянах нэгдсэн системийг
бий болгох чиглэлээр



Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллагын
Ардчилал, хүний эрхийн алба



*Empowered lives.
Resilient nations.*

“Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” МОН 13/102 төсөл©

Тус гарын авлагыг Монгол Улсын Их Хурал, Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн дэмжлэгтэйгээр орчуулав.

Денис Петит
Хуульт ёсны шинжээчдийн алба
Варшав,
2000

ЕРӨНХИЙ ХУРААНГУЙ

Сүүлийн жилүүдэд олон улсын хамтын нийгэмлэг нь сонгуулийн маргаанд нэлээд анхаарал хандуулах болсон. Олон улс оронд сонгуулийн тухай гомдол санал болон тэдгээрийг шийдэх дүрэм журмыг тойрсон улс төрийн маргаан, үл итгэлцэл нэлээд олон таа гарч байгаа нь ийнхүү анхаарал хандуулахад хүргэж байна. Хууль шүүхийн тогтолцоо болон сонгуулийн байгууллагууд нь хоорондоо уялдаа холбоо сул байхын зэрэгцээ, дотоодын хууль тогтоомж нь зөрчилтэй, хуулийн цоорхой их байдаг нь хоёрдмол (зэрэгцээ хоёр салаалсан) давж заалдах үйл явц үүсч бий болох, цаг хугацааны хувьд ойлгомжгүй байдал гарах, гомдол саналыг давхардуулж олон газарт гаргах, хууль зөрчсөн үйлдэлд тодорхой ял шийтгэл ногдуулах заалт байхгүй, хууль сахиулахад ярвигтай зэрэг олон саад бэрхшээл тулгардаг байна. Эдгээр бэрхшээлтэй асуудлын ноцтой нэг илрэл нь санал өгснөөс хойш маш олон гомдол санал ирдэг ч шийдэгдэхгүй үлдэх нь элбэг тохиолддог.

Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллагын Ардчилал, хүний эрхийн алба (OSCE/ODIHR)-наас 1998 онд хэрэгжүүлж эхэлсэн Олон улсын сонгуулийн стандартын хөтөлбөрийн үр дүнд тулгуурлан энэхүү тайланг бэлтгэв. Тус хөтөлбөрийн зорилго нь сонгуулийн маргааныг шийдэх тэргүүн туршлагыг бүрдүүлэхэд чиглэсэн болно. Тус хөтөлбөрийг Украин, Казакстан, Киргиз зэрэг улсуудад зөвхөн хэрэгжүүлсэн боловч хөтөлбөрийн үр дүнд боловсруулсан хяналт шинжилгээний стандарт арга зүйн бүтэц загварыг аль ч улс оронд улс төр, хууль эрх зүй, шүүхийн тогтолцооноос үл хамааран ашиглах боломжтой. Энэхүү арга зүйг Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллагын Ардчилал, хүний эрхийн алба (OSCE/ODIHR)-ны томилсон сонгууль ажиглах багийн стандарт форматад тулгуурлан боловсруулав.

Тус арга зүйн гол бүрэлдэхүүн хэсгүүдээс дурдвал:

(1) Сонгуультай холбоотой маргааныг шийдвэрлэх сайн туршлага хэмээн нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн арга барилыг тусгасан ерөнхий удирдамж

(2) Шүүх, сонгуулийн хороо болон төрийн бусад байгууллагуудад гаргасан сонгуулийн гомдлын талаарх мэдээлэл цуглуулах, нэгтгэх, боловсруулах, дүн шинжилгээ хийх, мөн холбогдох субъектуудын шийдвэрийг үндэслэн санал гомдлыг судалж шинжлэх тогтолцоо

(3) Сонгуулийн маргааныг шийдэх шүүхийн гүйцэтгэлийг үнэлэх арга хэрэгслүүд, үүнийг шүүхийн тогтолцооны ерөнхий гүйцэтгэлд нөлөөлөхүйц гол бэрхшээлийг тодорхойлоход ашиглах г.м.

Ерөнхий удирдамж нь сонгуулийн маргаан шийдэх нарийвчилсан загвар тогтолцоог тайлбарлаж тодорхойлох зорилго агуулаагүй. Тус удирдамжийн зорилго нь хууль дээдлэх зарчмын дагуу сонгуулийн маргаан шийдэхэд чиглэсэн параметруудийг тодорхойлохыг эрмэлзсэн болно.

Эдгээр параметрийг сонгуулийн хороо болон шүүх зэрэг гомдол гаргах хоёрдмол (хоёр салаалсан) журам үйл явцыг харгалзан боловсруулсан. Параметруудийг олон улсын эрх зүйн одоогийн актуудад тулгуурласны зэрэгцээ, олон улсын олон баримт бичигт тусгагдсан минимум стандартын талаарх нийтлэг хүлээн зөвшөөрдөг зөвшилцөл буюу байр суурьд үндэслэн боловсруулав.

Эдгээр удирдамжаас гадна сонгуулийн маргааныг шийдэх талаар шүүхийн систем, сонгуулийн хороо аль алины гүйцэтгэлийг үнэлдэг сонгуулийн маргааныг хянах стандарт тогтолцооны загварыг тусгасан буй. Энэхүү арга зүй нь тухайн улс орны сонгуулийн маргаан шийдэх үйл явцын талаар ойлгож мэдэхэд хялбар болохуйц өргөн хүрээтэй дүр зургийг харуулдаг. Үүнийг Сонгууль ажиглагчдын үйл ажиллагаатай уялдуулсан нь сонгуулийн маргаан болон эрх зүйн системийн аль алинд цогц дүн шинжилгээ хийх боломж олгож буй. Дээрх хоёр асуудлыг тус тусдаа авч үзэх нь тухайн асуудлын зорилгын хүрээнд учир дутагдалтай юм.

Сонгуулийн маргаан шийдвэрлэх гол цөм зарчмуудыг дээдлэх талаар уг эрх зүйн систем нь шаардлагатай заалтууд тусгасан эсэхийг хялбархан үнэлэх боломжийг сонгуулийн маргаан шийдвэрлэх схем олгодог. Уг схем нь тухайн хууль эрх зүйн тогтолцоо сонгуулийн маргааныг шийдвэрлэх чадвартай эсэхийг үнэлэх стратегийг тодорхойлно. Сонгууль ажиглагчдын анхаарлыг татсан гомдол саналыг холбогдох мэдээллийн санд тулгуурлан бүлэглэж, боловсруулсан болно. Энэхүү мэдээллийн сангийн зорилго нь тухайн улс орны сонгуулийн маргааны тоо болон мөн тэдгээрийн эрх зүйн ба сонгуулийн тогтолцооны маргаан шийдвэрлэх үйл явцын талаарх мэдээлэл цуглуулахад оршино. Боловсруулсан мэдээлэлд дараа нь эрх зүйн, сэдэвчилсэн, газар зүйн зэрэг бусад хэв шинжээр дүн шинжилгээ хийх боломжтой.

Түүнчлэн энэхүү арга зүйд чанарын үнэлгээний арга хэрэгслүүд, үүнд тухайлбал сонгуулийн маргааны шинжилгээний матрицыг тусгав. (матриц нь тодорхой асуултууд бүхий жагсаалт юм). Матрицын зарим асуулт нь нарийвчилсан дүн шинжилгээ хийх замаар сонгуулийн маргаан шийдвэрлэх эрх зүйн системийн давуу ба сул талуудыг бодитой илтгэж буй эсэхийг тодорхойлж тодруулах зорилготой. Бусад асуулт нь мэдээллийн санд бэлэн байгаа мэдээллээс холбогдох бусад мэдээ мэдээлэл цуглуулах бөгөөд тэдгээр нь тухайн улс орны эрх зүйн орчны хүрээнд маргаан шийдвэрлэх үр ашиг/үр дүнтэй байдал, чиг үүргийн хэрэгжилтийн талаар нарийвчилсан дүн шинжилгээ хийхэд ашиглана.

Уг арга зүйг Украин, Киргиз улсад сонгууль ажиглахаар томилогдсон Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллагын Ардчилал, хүний эрхийн алба (OSCE/ODIHR)-ны Сонгуулийн ажиглагчдын баг хэдийнээ ашигласан билээ. Сонгуулийн маргаан нь сонгууль ажиглах явцад байнга хөндөгддөг сэдэв боловч доор тайлбарласан систем нь мэдээлэл цуглуулж боловсруулах арга зам бүрдүүлэх, гомдол саналыг ангилж бүлэглэх, шийдвэрлэсэн байдлаар нь судлах, статистикийн нарийвчлалтайгаар чиг хандлага, хэв шинжийг илтгэн харуулах зэрэг өргөн хүрээтэй олон асуудлыг хамарсан болно.

I. ОРШИЛ

Сонгуулийн маргаан нь сонгууль болгонд нийтлэг олонтаа тохиолддог. Сонгуулийн үр дүнд шүүмжлэлтэй ханддаг гомдол саналын шалтгаан буюу үр дүн нь тухайн орны эрх зүйн тогтолцооны сул талын илрэл биш бөгөөд харин тус орны улс төрийн тогтолцооны давуулаг, нээлттэй, эрчхүчтэй болохыг нотлон харуулдаг илэрхийлэл юм. Иймд сонгуулийн маргааны олон талт байдал болон маргааны нийт тоо нэмэгдэж байгаа нь зарим талаар маргаан шийдвэрлэх үйл явцын талаар олон нийтийн ойлголт сайжирсантай холбоотой. Гэвч эрх зүйн тогтолцоо болон сонгуулийн удирдлага хөгжиж буй үе шатандаа яваа улс орнуудад энэхүү хандлага нь нэлээд бэрхшээлтэй хэвээр байна.

Сонгуулийн маргаан шийдвэрлэх онолын гол суурь асуудлууд:

- үр дүнгийн үнэ зөв болохыг баталгаажуулах, мөн улмаар сонгуулийн үр дүнг нягтлан шалгаж тогтоох эрхтэй байх
- сонгуульд санал өгөх эрхийг зөрчсөн зөрчлийг засч залруулахыг шаардах эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой санал гомдлыг шийдэх талаар сонгуулийн удирдлагын зүгээс авах захиргааны арга хэмжээнүүд
- сонгуулийн үйл явцыг гажуудуулсан буюу гажуудуулахыг оролдсон этгээдийн эсрэг эрүү үүсгэж шалгах г.м.

Эдгээр арга хэмжээ нь заавал тусдаа байх албагүй бөгөөд хослуулан нэг зэрэг ашиглах боломжтой.

Дээрх байдлаар асуудлуудыг энгийн хялбар ялгаж зааглахаас гадна, хууль эрх зүйн ба улс төрийн харилцан адилгүй уламжлалаас үүдэлтэй янз бүрийн аргачлал, механизмуудыг Засгийн газрууд нь сонгуулийн маргааныг шийдэхэд ашигладаг. Улс орнуудын сонгосон систем нь сонгуулийн ерөнхий тогтолцоотой уялдах бөгөөд үүнд холбогдох байгууллагууд, мөн дүрэм журмаас хамаарна. Ардчилал бэхжсэн улс орнуудад сонгуулийн маргааныг тусгай дүрэм журмын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг ердийн төрийн захиргааны болон шүүхийн байгууллагууд шийддэг байхад (ж: Их Британи, Герман, Франц, Итали), ихэнх хөгжиж буй улс оронд сонгуулийн маргааныг шийдэх чиг үүрэг нь ердийн шүүх болон сонгуулийн тухай хуулиар байгуулагдсан тусгай (байнгын ба түр) сонгуулийн хорооны хооронд хуваагдсан шинжтэй байдаг. Бас нэг загвар нь сонгуулийн маргааныг шийдэх байнгын чиг үүрэгтэй сонгуулийн шүүх байх бөгөөд энэ загвар нь Төв Америк, Өмнөд Америкийн зарим орон, мөн Грек, Зүүн Европын орнуудад түгээмэл байдаг.

Сонгуулийн маргаан шийдвэрлэдэг эрх зүйн үйл явцын олон загвар модель байдаг. Гомдол нэхэмжлэлийн талаарх эцсийн шийдвэрийг сонгуулийн хорооны бүтцийн хүрээнд гаргах буюу эсвэл ердийн шүүхийн тогтолцоо, мөн сонгуулийн шүүхийн чиг үүрэгтэй үндсэн хуулийн цэц гаргах нь ч бий. Түүнчлэн сонгуулийн маргаантай асуудлыг төрийн буюу сонгуулийн байгууллагаас захиргааны арга хэмжээ авах, эсвэл сонгуулийн будлианыг эрүү үүсгэн байцаан шийтгэх зэрэг янз бүрийн арга хэмжээ авч болно. Эцэст нь социалист иргэний эрх зүйт системтэй улс орнуудад сонгуулийн маргааныг шийдэх

барилд нөлөө үзүүлдэг нэг өвөрмөц чухал хэв шинж нь мөрдөн шалгах бүхий л үйл явцад прокурор шууд оролцдог арга барил юм.

Бүх улсад таарч тохирдог дан ганц арга зүй гэж байхгүй. Ямар загварыг сонгох эсэх нь ардчилсан үйл явцын үр дүнд зөвшилцсөн буюу хүрсэн үр дүнгээс шалтгаална. Гэвч тухайн улсын сонголтын шийдвэр нь хязгааргүй биш бөгөөд олон улсын стандарттай нийцүүлж уг сонголтыг хийх шаардлагатай. Хүний эрхийн зөрчлийг арилгах эрх нь угтаа хүний эрхийн нэг хэлбэр юм. Энэ нь сонгуульд санал өгөх эрхэд адил үйлчилнэ. Сонгуулийн маргааныг шийдэх талаар олон улсын эрх зүйн актад тусгайлан заагаагүй бөгөөд сонгуулийн маргааныг “шударга, үр дүнтэй, бодитой, шуурхай” шийдэх нийтлэг стандартын талаар олон улсын хамтын нийгэмлэг тодорхой зөвшилцөлд хүрсэн зүйл байхгүй. Гэвч одоогийн дүрэм журам, олон улсын хууль тогтоомжийн шаардлагуудаас үзэхэд, сонгуулийн маргаан шийдэхэд ашигладаг системүүдэд хүлээн зөвшөөрөхүйц олон талт, ялгаатай байдал нийтлэг байгааг тодорхойлох боломжтой.

Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Зөвлөлийн 1990 онд баталсан Копенгагений баримт бичгийг “чөлөөт, шударга” сонгуулийн талаар нэлээд цогц тусгасан олон улсын баримт бичиг гэж үздэг ч, үүнд сонгуулийн маргааны талаар илт тодорхой тусгаагүй. Гэвч сонгууль явуулах хүчин чармайлт нь хууль сахиулах эрх мэдлийг бүрдүүлээгүй цагт ердөө хоосон амлалт төдий байх болно. Тухайлбал, санал өгөх эрхийг зөрчсөн тохиолдолд нэхэмжлэл гаргах эрхийг хууль тогтоомжид баталгаажуулаагүй нөхцөлд санал өгөх эрх нь ердөө хийсвэр төдий зүйл байх болно. Хуулиар эрхээ сэргээлгэх тухай нэхэмжлэл гаргах эрх нь “хуулиар тогтоосон шаардлагатай тооны санал авсан нэр дэвшигч” нь “уг албан тушаалд сонгогдох” эрхэд ч адил үйлчилнэ. Хуулийн хамгаалалт байхгүйгээр сонгуультай холбоотой бүх эрх нь үнэ цэнгүй болно.

Түүнчлэн хэрэв хараат бус шүүхийн тогтолцоог болон хууль хэрэгжүүлэх угтвар нөхцлүүдийг хууль тогтоомжид баталгаажуулж, хэрэгжилтэд мөрдөөгүй нөхцөлд сонгуулийн маргаан шийдвэрлэх шударга, итгэл хүлээлгэхүйц систем оршин тогтнох боломжгүй юм. Үүнд шүүх хурлыг шударга явуулах, үр дүнтэй арга хэмжээ, хараат бус шүүхэд хандах зэрэг эрхүүд хамаарна. Эдгээр эрх болон зарчмууд нь хууль сахиулах аль ч системийн гол цөмд оршино. Гэвч сонгуулийн маргаан шийдвэрлэхэд шүүхээс гадна өөр субъект оролцдог тохиолдолд үүнд хэрэгжилтийн тусгай систем шаардлагатай. Үүнээс гадна энэ нь дангаараа сонгуулийн маргаан шийдэх бүх систем дагаж мөрдвөл зохих тодорхой параметрууд бүрдүүлэхгүй. Сонгуульд санал өгөхтэй холбоотой бүх эрхийг хэрэгжүүлэхийн тулд холбогдох эрх бүхий газруудын эсрэг гомдол/нэхэмжлэл гаргах эрхийг сонгуулийн системүүд бүрдүүлдэг хэдий ч, дээрх стандартад хүрэх ахиц дэвшлийг хэмжих арга зам, хэрэгслийг нарийн тодорхойлох хэрэгтэй. Олон улсын түвшний баримт бичгүүдэд одоогийн норм/хэм хэмжээг тусгасан байдаг ч, сонгуулийн маргаан шийдэхэд тодорхой шаардлагуудыг зориуд анхааран авч үзэх байдлаар тэдгээр хэм хэмжээг өргөжүүлэх боломжтой. Эдгээр баримт бичгүүдийн аль нь ч конвенцийн түвшинд хүрч чадаагүй боловч, стандарт тогтоохын ач холбогдлыг, ялангуяа сонгуультай холбоотой стандартыг чухалчлан практик хэрэглээнд тууштай нэвтрүүлэх зорилгоор ашиглаваас чухал хэрэгцээтэй баримт бичгүүд юм.

Хавсралт үзнэ үү.

7.9-р догол мөр, Копенгагений баримт бичиг.

4-р догол мөр, өмнөхтэй ижил.

Эрх чөлөө болон улс төрийн эрхийн үл явгаварлах ерөнхий зарчмуудын төсөл нь НҮБ-аас 1962 онд баталсан заавал мөрдөх статусгүй баримт бичиг бөгөөд үүнд бүх нийтийн сонгуулийн эрхийг хэрэгжүүлэх эрх мэдлийг анх удаа хүлээн зөвшөөрч энэхүү эрх нь зөрчигдсөн аливаа хувь хүн энэ эрхээ бие даасан, шударга шүүхийн өмнө сэргээлгэх эрхтэйг зааж тунхагласан. (XIX). Цаашилбал сонгуулийн хорооны шийдвэрийг шүүх, эсвэл бусад бие даасан, шударга байгууллагууд хянаж шалгадаг байх шаардлагыг тус баримт бичигт заасан. (VIII, d). “Ирээдүйн хүчин чармайлтын хүрээ гэх” 1989 онд НҮБ-аас гаргасан баримт бичигт “үндэсний байгууллагууд” нь бүх нийтийн сонгуулийн эрхийг эрх тэгш олгож, шударга сонгууль явуулахын тулд сонгуулийн маргаан шийдэх арга хэлбэрийг тодорхой хэмжээнд бүрдүүлэхийг уриалсан байдаг. (III: Үйл ажиллагааны асуудлууд).

Олон улсын бусад байгууллагуудын зарчмуудад улс төрийн ба сонгуулийн эрхийг хамгаалахад шаардлагатай минимум баталгааг тусгасан байдаг. Парламент-хоорондын зөвлөлийн “Чөлөөт, шударга сонгуулийн шалгуур үзүүлэлтүүдийн тунхаг” (1994) баримт бичигт нэр дэвшигч, улс төрийн нам, сурталчилгааны эрхийн зөрчлүүдийг тодорхойлж, “улс төрийн ба сонгуулийн эрхийн зөрчлийг сэргээх” эрхийн хамрах хүрээг өргөжүүлж тусгасан. (4). Түүнчлэн “сонгуулийн үйл явцын хугацаанд” шуурхай шийдвэр гаргах шаардлагыг дурджээ. (4.6, 4.8). НҮБ-ын баримт бичгүүдээс ялгаатай нь дээрх баримт бичигт сонгуулийн маргаан шийдвэрлэх үүрэг хариуцлагыг сонгуулийн хороонд илт даатган хариуцуулсан байдаг. (5.9). Одоогоор энэхүү Тунхаг нь сонгуулийн маргаан шийдвэрлэх талаар гарсан хамгийн үнэн бодит, тодорхой тусгасан баримт бичиг юм.

Эдгээр баримт бичгүүдэд тодорхойлсон зарчмуудаас 2 гол бүрэлдэхүүн хэсгийг онцлох боломжтой.

(1) Улсын төрийн ба сонгуулийн эрх нь зөрчигдсөн гэж үзсэн бүх иргэн, мөн улс төрийн нам нь гомдол санал гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй бөгөөд үүнд санал өгөх эрх, сонгогчоор бүртгүүлэх эрх, нэр дэвших эрх г.м. багтана.

(2) Сонгуулийн үйл явцтай холбоотой гомдлыг сонгуулийн хороо буюу шүүх зэрэг хараат бус, шударга, эрх бүхий байгууллагаар холбогдох хуулийн хугацаанд нь, үр дүнтэй шийдвэрлэх нөхцлийг хангах нь Улс орнуудын үүрэг хариуцлага болно.

Бодит практикт сонгуулийн маргаан шийдвэрлэдэг хэв шинж, тодорхой минимум стандартуудыг хангаж буй түвшний үнэлгээнд дараахь гол элементүүдийг жигнэж үнэлдэг.

Шүүх эрх мэдэл: Шүүх болон сонгуулийн хороод нь сонгуулийн маргаан шийдвэрлэх үүргийг хүлээдэг улс оронд шүүх эрх мэдэл нь томоохон ярвигтай асуудал байдаг. Сонгуулийн тухай хуульд буюу бусад эрх зүйн актуудад тусгасан хоёрдмол, дутуу дулимаг заалтууд нь шүүхийн болон сонгуулийн хороодын сонгуулийн маргаан шийдвэрлэх шүүх эрх мэдлийн талаар ойлгомжгүй байдал үүсгэж болзошгүй. ЕАБХАБ (OSCE)-ын бүс нутагт болж өнгөрсөн сүүлийн үеийн сонгуулийн үеэр шүүх болон сонгуулийн хороодын хооронд хүссэн үр дүндээ хүрэхийн тулд “форум шоп” буюу “нааштай шийдвэр гаргах

талд нэхэмжлэл гаргах" боломж бүрдүүлсэн ч, үүнийг гажуудуулсны улмаас сонгогдсон нэр дэвшигчид ажилдаа орох үйл явцад саад тотгор учрах, удаашрахад хүрсэн байна.

Шуурхай байдал: Сонгуулийн тухай хууль нь сонгуулийн үйл явцад нийцэж тохирсон цаг хугацааны дотор сонгуулийн маргааныг шийдвэрлэхийг батламжилж хуульчлах ёстой. Энэ нь сонгуулийн үр дүнг хойшлуулахгүй байх нөхцлийг хангахад нэн чухал ач холбогдолтой. Шуурхай гэдэг нь гомдол гаргахаас эхлэн түүнийг шийдэх хүртэлх хугацаа маш богино байхыг илтгэнэ. Энэ шаардлага нь шүүх засаглалын системд тулгамдсан асуудал юм. Үүнд шүүхийн тогтолцооны үр дүнтэй байдал, мөн шүүх болон сонгуулийн хороодын харилцаатай холбоотой чухал асуудлууд хөндөгддөг.

Хууль сахиулах: Шүүх болон сонгуулийн байгууллагын гаргасан шийдвэрийг зохистой, шуурхай хэрэгжүүлэх нь сонгуулийн маргаан шийдвэрлэх системийн үр дүнд маш чухал юм. Сонгуулийн удирдах байгууллага нь маргаан шийдэхэд голчлон оролцдог нөхцөлд хууль сахиулах асуудал илүү ноцтой болох хандлагатай. Тухайлбал, эцсийн шийдвэр гаргах эрх мэдлийг сонгуулийн дээд байгууллагад ногдуулахдаа түүний шийдвэрийг хэрэгжүүлэхүйц үр дүнтэй арга зам, хэрэгсэл, арга хэмжээ бүрдүүлээгүй бол энэ нь үр дүнгүй/явцуу зүйл болно. Улмаар энэ нь төрийн хууль сахиулах байгууллагуудын сонгуулийн үйл явцад гүйцэтгэх үүргийн талаар асуулт/шүүмж сөхөж тавихад хүргэдэг. Ихэвчлэн үндэсний хууль тогтоомжид төрийн байгууллагууд, хэвлэл мэдээлэл, төрийн албан тушаалтнууд эрх зүйн хэрэгжилтийг биелүүлээгүй нөхцөлд ногдуулах хариуцлагын талаар тусгаагүй байх нь түгээмэл байдаг. Эдгээр субъектийг давахуйц илүү эрх мэдэл сонгуулийн хороодод байдаггүй тул цаашилбал улс төрийн нам буюу нэр дэвшигчдийн хангасан шалгуурыг түдгэлзүүлэх буюу цуцлах шийдвэрийг завших тохиолдол гардаг.

Байцаан шийтгэх: Сонгуулийн үйл явцад гарсан авилгыг эрүүгийн хуулиар байцаан шийтгэж, хуулийн хариуцлага тооцох, үүнд мөнгөн торгууль, хорих ял оноох боломжтой ч, зөвхөн шүүхэд ийм эрх мэдэл олгосон байдаг. (хөнгөн ял шийтгэлээс бусад тохиолдолд). Сонгуулийн маргаан болон түүнтэй холбоотой эрх зүйн шийтгэлийн талаар эрүүгийн хуульд зааж тусгах нь зүйтэй. Эрүүгийн байцаан шийтгэх болон сонгуулийн байгууллагын албан тушаалтны захиргааны арга хэмжээг уялдуулан ашиглах боломжтой. Түүнчлэн эрүүгийн байцаан шийтгэх арга хэмжээ тухайн хэрэгт зохистой эсэх нь мөн ярвигтай асуудлын нэг юм. Ялангуяа хууль сахиулах байгууллагууд, холбогдох яамдын хэлтсүүдийн эрүүгийн байшаан шийтгэх ажиллагааг эхлүүлж, сонгуульд нөлөөлөхүйц хүчин зүйлийг арилгах, багасгахад чиглэсэн байдлаар хэрэгжүүлбэл зохино. Эдгээр нь стандарт хяналт шинжилгээний тогтолцооны төдийгүй энэхүү тайланд тусгасан сонгуулийн маргаан шийдвэрлэх ерөнхий удирдамжийн дөрвөн гол тулгуур асуудал болно.

II. СОНГУУЛИЙН МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ЕРӨНХИЙ УДИРДАМЖ

Дараахь удирдамж нь сонгуулийн маргаан шийдвэрлэх загвар системийг дэлгэрэнгүй тайлбарлаж тодорхойлох зорилго агуулаагүй болно. Тус удирдамжийн зорилго нь

сонгуультай холбоотой маргааныг шийдвэрлэхэд нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг сайн зарчим, туршлагуудыг тодорхойлоход чиглэнэ. Үүнд сонгуулийн маргаан шийдвэрлэх механизмуудад хууль дээдлэх ёсыг хангахад чиглэсэн параметруудийг тусгасан.

Дэлхийн улс орнуудын эрх зүйн болон сонгуулийн тогтолцоо харилцан адилгүй тул засвар тохиргоо хийх шаардлагатай ч, доорх стандартууд нь хэрэгжилтэд тулгардаг бэрхшээлүүдийг шийдэхүйц хүчин чармайлтыг сайжруулахад чиглэсэн болно. Ерөнхийдөө, уг стандартууд нь олон улсын хамтын нийгэмлэгийн нийтлэг хүлээн зөвшөөрдөг минимум нөхцлүүдийг илтгэдэг. Стандартууд нь онол, практик байнга боловсронгуй болж буй салбарт хамаарч байгаа тул, хууль дээдлэх ёс болон чөлөөт, шударга сонгуулийг нэгтгэж уялдуулах зорилготой төдийгүй эдгээр стандартад нийцдэг аливаа бусад туршилт, үйл ажиллагааг үгүйсгэх зорилгогүй.

Дордурдсан зарчмуудыг сонгуулийн маргаан шийдэхүйц явцад сонгуулийн байгууллагууд болон шүүх аль аль нь оролцсон холимог дүрэм журамд тулгуурлан боловсруулж, томъёолов. Сонгуулийн маргаан, давж заалдах нэхэмжлэлийг шийдүүлэхээр тусгай шүүх байгуулах, эсвэл сонгуулийн маргааныг шүүх эрх мэдэлтэй захиргааны шүүхийн тогтолцоотой гэх мэт альтернатив дүрэм журмыг зарим улс орнууд хэрэгжүүлдэг. Гэвч эдгээр альтернатив хэлбэрүүдийг ихэвчлэн санхүүгийн шалтгаанаар хүлээн зөвшөөрөх, хэрэгжүүлэх боломж бололцоо маш хязгаарлагдмал байна.

Эцэст нь эдгээр зарчим нь олон улсын түвшний хууль дээдлэх ёс болон сонгуулийн стандартуудын огтлолцол дээр орших буюу ө.х. харилцан хамааралтай юм. Зарим зарчим нь шударга ёс буюу олон улсын эрх зүйн актуудад тусгагдсан суурь дүрмүүдэд хамаарч байхад, бусад нь практик хэрэгжилтэд илүү хамаарна. Тус зарчмууд нь (i) Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Комисс (ЕАБХАК/CSCE)-ын Хүний эрхийн бага хурлын Копенгагений уулзалтын баримт бичгийн 5.10-р догол мөр, (ii) ЕАБХАК-ийн Виеннагийн Дүгнэлт баримт бичгийн 13.9-р догол мөр, (iii) Хүний эрхийн тухай Европын конвенцийн 6-р Зүйлд тус тус заасан шударга шүүх хурлаар шийдвэрлүүлэх эрхтэй холбоотой дүрэм журмын үндсийг илтгэнэ. Ялангуяа үүнд шүүхийн бие даасан байдлын талаар ЕАБХАК-ийн Хүний эрхийн бага хурлын Москвагийн уулзалтын баримт бичгийн 19, 20, 21-р догол мөрт тодорхой заасан бий.

Копенгаген, 1990 оны 6-р сарын 29.

Гуравдугаар дагалдах хурал, Виенна, 1989 оны 1-р сарын 19.

Хүний эрх, суурь эрх чөлөөг хамгаалах тухай конвенц, Ром хот, 1950 оны 11-р сарын 4.

“Шүүхийн бие даасан статусын үндсэн зарчмууд”, 1985 оны 8-р сарын 26-наас 9-р сарын 6-ны өдөр хүртэл Милан хотноо хуралдсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг шийтгэх тухай НҮБ-ын 7-р конгресс”-оор боловсруулж гаргасан бөгөөд 1985 оны 11-р сарын 29-ны өдөр гаргасан Ерөнхий Ассамблейн 40/32-р тогтоол, мөн 1985 оны 12-р сарын 13-ны өдөр гаргасан 40/146-р тогтоолоор баталгаажуулсан.

Москва, 1991 оны 10-р сарын 3.

А. Ерөнхий зарчмууд

1. Аливаа иргэн буюу улс төрийн нам нь улс төрийн болон сонгуулийн эрхээ хуулиар хамгаалуулах, хэрэв эдгээр эрх нь зөрчигдсэн тохиолдолд сэргээх арга хэмжээ авахуулах эрхтэй.
2. Нэр дэвшигчид, улс төрийн нам, сонгуулийн сурталчилгааны эрхийг зөрчсөн буюу хязгаарласан тохиолдолд аливаа иргэн буюу улс төрийн нам нь гомдлоо холбогдох эрх бүхий байгууллагад гаргах эрхтэй.
3. Зөрчил гарсныг илрүүлсэн тохиолдолд зохих хуулийн эрх мэдэлтэй, холбогдох эрх бүхий байгууллага нь уг зөрчигдсэн эрхийг сэргээх арга хэмжээг сонгуулийн үйл явцын хугацаанд шуурхай авч хэрэгжүүлнэ.
4. Шүүх тогтолцоо, прокурор, сонгуулийн байгууллагуудын үр дүнтэй, шударга, хараат бус байдал нь сонгуулийн талаарх олон улсын түвшний стандарт, хууль дээдлэх ёсны дагуу сонгуулийн маргааныг шударга, үр дүнтэй, бодитой шийдэх угтвар нөхцлийг бүрдүүлнэ.
5. Сонгуулийн үйл явцыг хянах, олон нийтийн бусад зөвлөлгөөн, сонгогчдын жагсаалт бэлтгэх, тогтмол хянаж шалгах зэрэг үүргийг хариуцсан хараат бус, шударга эрх бүхий байгууллагын шийдвэрүүдийг хараат бус, шударга шүүхэд давж заалдах эрхтэй.
6. Сонгуулийн тухай хуульд шүүх болон сонгуулийн байгууллагын холбогдох эрх мэдлийг нарийн тодорхой зааглах шаардлагатай бөгөөд энэ нь ижил асуудлаар давхардуулж буюу зэрэг гомдол гаргах боломжийг хязгаарлана.

Б. Шаталсан давж заалдах журам

7. Сонгуулийн тухай хуульд сонгуультай холбоотой гомдол, давж заалдах нэхэмжлэлийг шийдэх талаар шүүх ба иргэний хэргийг зохицуулдаг эрх зүйн орчны дагуу шаталсан давж заалдах журмыг тодорхой тусгах шаардлагатай.
8. Сонгуулийн тухай хуульд дээд шатлалын шүүх буюу сонгуулийн төв байгууллага бүх хэргийг хянан үзэх нөхцлийг бүрдүүлэхийн тулд наанадаж нэг (1-ээс доошгүй) давж заалдах журам тусгах хэрэгтэй. Уг хуулинд аль шийдвэр нь эцсийнх болох талаар тодорхой заана. Тухайн шийдвэрийг хянан магадлан бололцоотой нөхцөлд, аль шүүх, сонгуулийн байгууллагад давж заалдах боломжтойг зүйлчлэн заах хэрэгтэй.
9. Шүүхэд хандахаас өмнө сонгуулийн байгууллагаар заавал хянан магадлуулах угтвар нөхцөл шаардлага байх ёсгүй бөгөөд шүүхэд хэзээ ч давж заалдах эрхтэй байвал зохино.
10. Сонгуулийн бүүхий л маргааны талаар сонгуулийн дээд байгууллагын гаргасан шийдвэрүүдийг шүүхийн дээд шатны байгууллага хянан магадлах боломжтой нөхцөлд

шүүхийн шийдвэр нь эцсийн шийдвэр байна.

11. Доод шатны шүүхийн шийдвэрийг дээд шатны шүүх хянан магадлах тухай хуульд заасан бол, үүнийг ерөнхий дүрмийн онцгой тохиолдол гэж үзэн, хуульд нарийн тодорхой зааж тусгах хэрэгтэй. Доод шатны шүүхийн шийдвэрийг чухам аль шүүхэд давж заалдах тухай хуульд маш тодорхой заах хэрэгтэй.

12. Сонгуулийн тухай хуульд аль шийдвэр нь эцсийн бөгөөд заавал дагаж мөрдөх талаар зааж зүйлчлэх хэрэгтэй. Дээд шүүх буюу үндсэн хуулийн цэц нь доод шатны шүүхэд сонгуультай холбоотой хэргийг шилжүүлэх боломжгүй буюу ёсгүй.

В. Хүртээмж ба ил тод байдал

13. Гомдол шийдвэрлэх журам нь ил тод, ойлгомжтой байх ёстой. Гомдол гаргах, давж заалдахад ашигладаг загвар маягт нь тухайн улс орны хэл дээр, бэлэн, олдоцтой байвал зохино. Сонгуулийн хороо/хэсгийн ажилтнуудад гомдол гаргах дүрэм журам, мөн сонгуулийн маргааныг зохицуулах стандарт, ийм асуудалд тэдний оролцох хэм хэмжээний талаар танилцуулж мэдээлэх хэрэгтэй. Эцэст нь иргэний боловсролын кампанит ажилд гомдол шийдвэрлэх журмын талаар үндсэн мэдээлэл тусгах нь зүйтэй.

14. Тухайн орны сонгуулийн тухай хууль, олон улсын стандартуудын дагуу сонгуулийн маргаан шийдвэрлэх дүрэм, журмын талаарх сургалтад сонгуультай холбоотой үүрэг хүлээсэн ажилтнуудыг хамруулах бодлого, институцийн арга хэмжээг холбогдох эрх бүхий байгууллагууд нь авч хэрэгжүүлбэл зохино.

15. Гомдол гаргах журам нь шаардлагагүй саад тотгороос аль болохоор зайлсхийсэн, ялангуяа шүүхэд гомдол гаргах өртөг зардалгүй байвал зохино. Гомдол гаргах журам нь гомдол гаргагчдад үнэ төлбөргүй, хүртээмжтэй байх ёстой. Өртөг зардлаас зайлсхийх боломжгүй нөхцөлд тухайн иргэн гомдол гаргахад нөлөөлөхгүй хэмжээнд төлбөрийг минимум түвшинд байлгавал зохино.

16. Үр дүнтэй, шударга, ил тод байдлыг хангасан маргаан шийдвэрлэх журам нь ямар арга хэлбэрээр гомдол гаргах боломжтой мэдээллийг боломжит гомдол гаргагчдад бүрдүүлэх, ямар субъектүүдэд хандах, маргаан шийдвэрлэх хугацаа зэргийг тусгасан байх шаардлагатай. Түүнчлэн гомдол гаргагчид нь өөрсдийн гомдлыг нотлох хангалттай баримт, материалын төрөл, хэмжээний талаар ойлголт мэдлэгтэй байвал зохино.

17. Сонгуулийн байгууллагуудын гаргасан шийдвэр, үүнд ялангуяа сонгогчид буюу нэр дэвшигчдийн бүртгэлтэй холбоотой шийдвэрүүд нь зөрчлийг арилгахад авсан/хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн талаар тусгах ёстой гэсэн нийтлэг дүрэм байдаг.

1990 оны 6-р сарын 29-ны өдөр болсон ЕАБХАБ-ын Копенгагений хурлын Баримт бичгийн 5.10-р догол мөрт тусгасан ерөнхий зарчимтай энэ зарчим нь нийцэж буй.

18. Сонгуулийн маргаан шийдвэрлэх механизмуудыг эрх зүйн хэм хэмжээний акт, ялангуяа холбогдох хуулийн бие даасан бүлэг буюу хэсэгт тусгаж зохицуулах хэрэгтэй. Сонгуулийн маргааны тухай заалтуудын нэр томъёо, хэл найруулга, эрх зүйн хамрах хүрээ зэрэг нь харилцан уялдаатай байж, тэдгээрийн харилцан хамаарал, бүрэн бүтэн байдлыг хангах ёстой. Хуулийн хэл найруулга нь тодорхой, ойлгомжтой байх бөгөөд улмаар аливаа дурын хөрвүүлгээс зайлсхийсэн байвал зохино.

Г. Гомдол шийдвэрлэх үйл явцын шуурхай байдал: хугацааны хязгаар, эцсийн хугацаа

19. Сонгуулийн үйл явцыг тогтоосон хугацааны дотор шийдвэрлэж, арга хэмжээ авах шаардлагатайг анхаарахын сацуу, сонгуулийн маргааныг зохицуулах дүрэм журам нь ерөнхий иргэний эрх зүйн маргаанаас ялгаатай байх ёстой. Хугацааг богино тогтоон, нэг удаагийн давж даалдах эрхтэй байхаар тусгаж болох хэдий ч, гомдол гаргах болон давж заалдахад хангалттай хугацаа байх шаардлагатай.

20. Маргаан шийдэх хугацааны хязгаарыг тогтоохдоо, шүүхийн удирдлагатай холбоотой үүрэг хариуцлагуудын харгалзан тэнцвэртэй, шуурхай, сонгуулийн хугацаанд, сонгуулийн байгууллагуудын гаргасан шийдвэр, үйлдэл, эс үйлдлийг давж заалдах эрхийг хангахуйц байдлаар тогтоож тодорхойлбол зохино.

21. Ялангуяа хугацааны хязгаар нь шүүх болон сонгуулийн байгууллагууд нь тэдгээрт гаргасан гомдол, давж заалдах хүсэлтийг хянан магадлах, шийдэхэд хангалттай хугацаа олгосон байх хэрэгтэй. Зарим гомдол, давж заалдах нэхэмжлэл, ялангуяа сонгуулийн санхүүжилт буюу сурталчилгаатай холбоотой асуудалд нарийвчилсан мөрдөн шалгалт шаардлагатай байдгийг харгалзан үзэх нь зүйтэй.

22. Шүүх болон сонгуулийн байгууллагууд нь өргөдөл, гомдол, эсэргүүцэл, давж заалдах нэхэмжлэл хүлээж авахгүй эцсийн хугацааг сонгуулийн хуульд сонгуулийн үйл явцын үе шат буюу бүрэлдэхүүн хэсэг бүрээр маш тодорхой, системтэй тусгавал зохино. Сонгогчдын бүртгэл буюу нэр дэвшигчдийг батламжлах талаар гомдол, давж заалдах нэхэмжлэл гаргах хугацааны хязгаарыг тусад нь зааж зүйлчлэх боломжтой.

23. Сонгуулийн хуульд шүүх эсвэл сонгуулийн байгууллагад гаргасан гомдол, давж заалдах нэхэмжлэлийг шийдвэрлэх эцсийн хугацааг сонгуулийн үйл явцын үе шат буюу бүрэлдэхүүн хэсэг бүрээр (сонгогчдын жагсаалт, нэр дэвшигчдийг батламжлах г.м.) маш тодорхой, системтэй тусгах хэрэгтэй. Сонгогчдын бүртгэл буюу нэр дэвшигчдийг батламжлах талаар гомдол, давж заалдах нэхэмжлэл гаргах хугацааны хязгаарыг (нийтлэг дүрэм журмаас гадна) тусад нь зааж зүйлчлэх боломжтой.

24. Эрүүгийн шинжтэй гэж үзэхуйц зөрчлийн талаарх гомдол гаргасан тохиоолдолд, эрх бүхий байгууллагууд нь мөрдөн шалгах ажиллагааг шударга, бодитой, мэргэжлийн түвшинд оновчтой явуулах нөхцлийг бүрдүүлэхэд онцгой анхаарах шаардлагатай.

Д. Сонгогчдын бүртгэл

25. Бүх иргэн сонгогчдын бүртгэлийн үнэн бодит эсэх талаар гомдол гаргах, давж заалдах эрхтэй байх ёстой.

26. Сонгуулийн хуульд сонгогчдын нэрсийн жагсаалт/бүртгэлийн талаар өргөдөл, гомдол, эсэргүүцэл хүлээж авах (түүнээс хойш хүлээж авахгүй байх) эцсийн хугацааг тусгах хэрэгтэй. Хуулиар сонгогчдын нэрсийн жагсаалтын үнэн бодит эсэх талаар сонгуулийн өмнөх өдөр гомдол гаргах боломж олгохыг хориглоно. Энэ нь сонгуулийн болон шүүх байгууллага нь санал өгөх болон санал тоолохтэй холбоотой нэн яаралтай гомдол, давж заалдах нэхэмжлэлийг шийдвэрлэхийн оронд өмнө шийдвэрлэх ёстой байсан маргааныг шийдэхэд хүч анхаарлаа зарцуулахад хүрэхээс зайлсхийх боломж бүрдүүлнэ.

27. Сонгуулийн хуульд сонгогчдын нэрсийн жагсаалт буюу сонгуулийн үнэмлэхийн үнэн бодит эсэх талаарх гомдол, давж заалдах нэхэмжлэл гаргах тусгайлсан газрыг зааж зүйлчлэх хэрэгтэй. Шүүхийн байгууллагууд нь хэт жижиг маргаан, гомдолд дарагдахгүй байх нөхцлийг харгалзан гомдол шийдвэрлэх журмыг боловсруулбал зохино.

Е. Нэр дэвшигчдийг батламжлах

28. Нэр дэвшигчдийг батламжлахтай холбоотой гомдол хүлээж авах эцсийн хугацааг сонгуулийн хуульд тусгах шаардлагатай. Нэр дэвшигчдийг баталгаажуулах үйл явцын эцсийн хугацааг зохистой байдлаар тохируулж тодорхойлох хэрэгтэй.

29. Сонгуулийн хуульд нэр дэвшигчдийг дэмжсэн гарын үсгийг нягтлан шалгаж баталгаажуулах журмын талаар зааж тусгавал зохино.

Ё. Сонгуулийн үр дүн

30. Сонгуулийн хуульд сонгуулийн үр дүнг хүчингүйд тооцох механизмыг тодорхой тусгах хэрэгтэй. Парламентийн болон ерөнхийлөгчийн сонгуулийн аль алинд сонгуулийн үр дүнг хэсэгчлэн болон бүрэн хэмжээгээр хүчингүйд тооцох шийдвэр гаргах эрх мэдлийг сонгуулийн дээд/төв байгууллагад олгох ёстой. Уг шийдвэрийг Дээд шүүх буюу Үндсэн хуулийн цэц зөвхөн хянан магадлах эрхтэй байвал зохино.

31. Эрх бүхий субъект нь албан ёсны гомдол хүлээж аваагүй боловч сонгуулийн үр дүнг хүчингүйд тооцох боломжтой эсэх, мөн тухайн субъект нь шийдвэрийг сонгуулийн санал өгөх хэсэг тус бүрээр гаргах эсэх талаар сонгуулийн хуульд тодорхой заах хэрэгтэй. Хуулинд сонгуулийн үр дүнг хүчингүйд тооцох ерөнхий механизм үйлчлэх нөхцлүүд, мөн гомдол, давж заалдах нэхэмжлэл хүлээж авах эсэх талаар маш тодорхой тусгах шаардалгатай.

32. Урьдчилсан болон эцсийн үр дүнгийн аль алины талаар гомдол гаргах эрхийг

хэрэгжүүлэх боломж нөхцлийг хангаж өгөх хэрэгтэй. Иймд сонгуулийн хуульд урьдчилсан ба эцсийн үр дүнгийн талаар гомдол гаргах журам болон эцсийн хугацаа зэргийг ялгавартай тогтоох хэрэгтэй. Доорх зарчмууд нь энэхүү төсөөлөлд суурилсан болно.

33. Доод шатны сонгуулийн байгууллага нь сонгуулийн урьдчилсан үр дүнг нийтлэх үүрэгтэй нөхцөлд, тэдгээр байгууллага нь сонгуулийн үр дүнг хүчингүй гэж зарлах эрхгүй боловч ийм агуулгатай (заавал биелүүлэх албагүй) зөвлөмжийг сонгуулийн дээд/төв байгууллагад гаргах боломжтой байвал зохино.

34. Дээд шүүх буюу Үндсэн хуулийн цэц урьдчилсан үр дүнгийн талаарх бүх гомдол, саналыг шийдэхээс өмнө эцсийн үр дүнг хэвлэж нийтлэх ёсгүй.

35. Доод шатны сонгуулийн байгууллагын чиг үүргийн хүрээнд сонгуулийн урьдчилсан үр дүнгийн талаарх гомдлыг сонгуулийн дээд/төв байгууллагад гаргах шаардлагатай бөгөөд энэ нь уялдаатай, шаталсан дүрэм журмыг хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлнэ. Ийм гомдол гаргах, шийдвэрлэх эцсийн хугацаа нь нэг сараас хэтрэх ёсгүй бөгөөд энэ нь (урьдчилсан үр дүнг зарлаж нийтлэх эцсийн хугацааг харгалзан) эцсийн үр дүнг энэ хугацаанаас хэтрүүлэлгүй зарлаж, нийтлэх боломж олгоно.

36. Эцсийн үр дүнгийн тухай буюу сонгуулийн үр дүнг хэсэгчлэн болон бүхэлд нь хүчингүйд тооцсон талаар зарлахтай холбоотой бүхий л гомдол саналыг дээд шүүх буюу үндсэн хуулийн цэцэд, эсвэл сонгуулийн дээд/төв байгууллага байршдаг нутаг дэвсгэрийн шүүхэд гаргах ёстой. Сонгуулийн дээд/төв байгууллага байршдаг нутаг дэвсгэрийн шүүхэд гаргах дээрх гомдлыг гаргасан тохиолдолд холбогдох шийдвэрийг дээд шүүхэд давж заалдах боломжтой.

37. Урьдчилсан болон эцсийн үр дүнг зарлах/нийтлэх хугацаа болон гомдол гаргах, шийлдвэрлэх талаар хуулинд заасан журмын дагуу бүх гомдол, давж заалдах нэхэмжлэлийг максимум 2 сарын дотор нэг мөр, бүрэн шийдвэрлэх шаардлагатай.

38. Сонгуулийн үр дүнг хэсэгчлэн болон бүхэлд нь хүчингүйд тооцох үндэслэлүүдийг сонгуулийн хуульд тодорхой зааж зүйлчлэх хэрэгтэй. Үндсэн хуулийн ишлэл төдий нь ийм хэргийг шүүн таслах хангалттай үндэслэл болохгүй. Түүнчлэн хуульд сонгуулийн үр дүнг хянан магадлахад шаардлагатай нотолгооны төрөл, хэмжээг тодорхой зүйлчлэх шаардлагатай. Нотолгооны талаар тодорхой, ойлгомжтой стандарт байхгүй нөхцөлд эдгээр стандартыг ямар нотолгоо хангах эсэхийг тодорхойлохын тулд нийт үйл явцыг сулруулж болзошгүй түвшингээс хамааран харилцан адилгүй байх боломжтой.

39. Сонгуулийн санал өгөх хэсэг тус бүрээр сонгуулийн үр дүнг шийддэг механизмтай нөхцөлд, тухайн санал өгөх хэсгийн саналыг хүчингүйд тооцохын тулд нь тухайн алдаа, зөрчөл хэрхэн сонгуулийн үр дүнд нөлөөлсөн байдлыг үнэлэх хэрэгтэй.

Ж. Гомдол, давж заалдах нэхэмжлэлийн хүлээж авах

40. Гомдол, давж заалдах нэхэмжлэлийг хүлээж авах үндэслэлийг сонгуулийн хуульд тодорхойлох хэрэгтэй. Гомдол гаргагчийн гомдлыг хүлээн авах үндэслэлтэй эсэх, мөн ямар шалтгаанаар хүлээж авсан болохыг тухайн гомдол гаргагчид бичгээр мэдээлэх ёстой.

41. Давж заалдах үндэслэлийг хуульд заавал тодорхой заасан байх, ялангуяа сонгуулийн маргааны механизм оролцсон үе шат бүрээр үндэслэлийг тусгаснаар сонгуулийн байгууллагууд нь холбогдолгүй, үндэслэлгүй гомдол, саналд дарагдахгүй байх боломж бүрдэнэ.

42. Шүүх болон сонгуулийн байгууллагад хандан сонгуультай холбоотой гомдол, давж заалдах нэхэмжлэл гаргах эрхтэй талуудыг сонгуулийн хуульд нарийвчлан тодорхойлох хэрэгтэй.

43. Гомдол гаргагч тал зөрчил дутагдлыг арилгахыг шаардах эрхийг хангахуйц байдлаар гомдол, давж заалдах нэхэмжлэл хүлээж авахыг зохицуулсан хугацааг тогтоож, журмыг боловсруулах нь зүйтэй.

3. Хууль сахиулах

44. Сонгуулийн маргаан шүүн таслах эрх бүхий байгууллагууд нь тухайн шийдвэрүүдийг үндэслэлтэй хугацаанд хэрэгжүүлж сахиулах эрх мэдлээр хангагдсан байх ёстой. Шүүхийн удирдлагыг зохицуулдаг сонгуулийн тухай хууль, тогтоомжид сонгуулийн маргааныг шүүн таслах эрх мэдэлтэй байгууллага/субъектүүдийн гаргасан шийдвэрүүдийн эрх зүйн үр нөлөөг тодорхой зааж тусгах хэрэгтэй. Түүнчлэн торгууль, хорих ял, нэр дэвшигчийг түдгэлзүүлэх, татгалзах зэрэг эрх зүйн ял шийтгэлийг ногдуулах, сахиулж хэрэгжүүлэх талаар хуульд маш тодорхой зааж зүйлчлэх шаардлагатай.

И. Сонгуулийн маргааны талаарх заалтуудыг хөрвүүлэх, хэрэгжүүлэх уялдаа хамаарал

45. Сонгуулийн байгууллагууд нь сонгуулийн хуулийг нэгдсэн байдлаар хөрвүүлж ойлгох, ашиглах боломжийг хангахын тулд зохицуулалт буюу зааварчилгаа баталж гаргах эрх үүргийг сонгуулийн төв байгууллагад ногдуулсан болохыг сонгуулийн хуульд тодорхой заах хэрэгтэй.

46. Эрх зүйн орчин (Иргэний хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль г.м. бусад хуулиас давуу эрхтэйд тооцогдох) буюу сонгуулийн тухай хууль тогтоомж нь аливаа давхардал, цоорхой, орхигдолгүй байх нөхцлийг Дээд шүүх хариуцаж хангана.

47. Дээд Шүүх нь өмнөх шүүн тасалсан хэргүүдийн шийдвэрийг багцлан бэлтгэж, шүүгчид тэр хэргүүд болон шалтгаан үндэслэлтэй танилцсан эсэх талаар арга хэмжээ

авч ажиллана.

48. Сонгуультай холбоотой хэргүүдийн талаар эцсийн бөгөөд эрх зүйн шийдвэр гаргах эрх үүрэгтэй сонгуулийн хороод ба дээд шүүхийн шатлалын хүрээнд хамгийн дээд субъект нь сонгуулийн маргаанд хамаарах олон асуудлын талаар зааварчилгаа, удирдамж, тогтоол шийдвэр зэргийг сонгуулиас өмнө хамтран боловсруулж гаргах шаардлагатай. Гомдол, давж заалдах нэхэмжлэл гаргах хоёр тусдаа бүтэц/үйл явц байх нөхцөлд, тухайн хоёр байгууллага нь өөрсдийн болон доод шатлалын шүүх болон сонгуулийн хороодын чадамжийг тодорхой тодруулах хэрэгтэй. Сонгуультай холбоотой хэргүүдэд тулгуурлан сонгуулийн талаарх эрх зүйн орчин буюу шүүхийн үйл ажиллагаа, стандартыг шинэчлэл хийхэд дээрх баримт бичгүүд нэн чухал үүрэг гүйцэтгэх боломжтой. Байгууллагууд хоорондын зөрчил буюу үл ойлголцол нь сонгуулийн тухай хууль, зохицуулалтыг доод шатанд хөрвүүлж, хэрэглэхэд ноцтой сөрөг нөлөө үзүүлж болзошгүй төдийгүй тухайн хуулийн тодорхой ойлгомжтой байдал, сонгуулийн үйл явцад итгэх итгэл үнэмшилд эрсдэл учруулах талтай.

Й. Сонгууль болон сонгуулийн хуультай холбоотой зөрчлүүд

49. Сонгуулийн тухай хуульд сонгуулийн үйл явцад гарч болзошгүй зөрчил, дутагдлын ангиллын жагсаалт, тэдгээрийн сонгуулийн үйл явцад нөлөөлж болзошгүй үр дагаврыг тусдаа бүлэг, зүйл заалтад тусгах шаардлагатай. Тухайн хууль буюу үндсэн хуулийн зөрчих тухай товч ишлэлээс зайлсхийвэл зохино.

50. Тэдгээр зөрчил, дутагдал нь сонгуулийн үйл явцад үзүүлж буй нөлөөг тодорхойлох стандартуудыг нарийвчлан сонгуулийн тухай хуульд тусгах хэрэгтэй.

51. Эрүүгийн байцаан шийтгэх зүйл ангид хамааралтай сонгуулийн зөрчлүүдийг Эрүүгийн хуулийн тусгай бүлэгт зааж зүйлчлэхийн зэрэгцээ сонгуулийн хуульд энэ талаар ишилж дурдвал зохино. Сонгуулийн тухай хууль болон эрүүгийн хууль, эрүүгийн байцаан шийтгэх хуулийн заалтууд харилцан уялдаа хамааралтай байхад онцгой анхаарч, улмаар тэдгээртэй холбоотой эрх зүйн арга хэмжээний талаар аливаа үл ойлголцол үүсэхээс зайлсхийх хэрэгтэй.

К. Байцаан шийтгэх

52. Эрүүгийн байцаан шийтгэх зүйл ангид хамааралтай хэргүүдийг холбогдох газруудаар шалгуулж, эрүүгийн шүүн таслах үйл явцыг зохицуулдаг хуульд заасан дүрэм журам, стандартын дагуу шийдвэрлэх шаардлагатай. Энэ нь шүүх буюу сонгуулийн хороод нь тухайн зөрчил сонгуулийн үйл явцад хэрхэн нөлөөлж буй үр нөлөөг тодорхойлоход саад болохгүй.

53. Сонгуультай холбоотой хэргийг эрүүгийн шүүн таслах байгууллага мөрдөн шалгах нөхцөлд баримтлах стандартуудыг хуульд тодорхой зааж тусгах хэрэгтэй. Ялангуяа

байцаан шийтгэхэд хангалттай нотолгоо байгаа эсэхийг шийдвэр гаргахдаа ашиглах стандартуудыг зүйлчлэх шаардлагатай. Эдгээр стандартуудыг сонгуулийн тухай хуульд эсвэл эрүүгийн хуульд тогтоомжид тодорхой зааж тусгавал зохино. Энэхүү тодорхой асуудлыг зохицуулдаг бүх хууль болон бусад эрх зүйн чадамжтай дүрэм журмууд нь харилцан уялдаа хамаарал, нийцлийн хангахын тулд маш тодорхой ишлэл/тодруулгыг тусгаж дурдсан байх шаардлагатай.

54. Хуульд байцаан шийтгэх эрх мэдлийн хүрээг нарийн тусгах шаардлагатай. Ялангуяа энэхүү эрх мэдлийг тодорхойлоход ашиглаж буй нэр томъёог тодорхой хуульчилсан байвал зохино. Хуульд энэхүү эрх мэдлийг хязгаарласан тохиолдолд тэдгээр хязгаарлалтыг тодорхойлохгүй үлдээж болохгүй. Сонгуультай холбоотой зөрчил дутагдлыг байцаан шийтгээгүй үндэслэлийг тодорхой дурдах шаардлагатай бөгөөд үүнд төр засаг, нийгмийн эрх ашиг гэж ерөнхийчлэхөөс зайсхийх нь зүйтэй. Байцаан шийтгэх эрх мэдлийн хязгаарлалтыг тодорхойлсон зүйл заалтууд нь бусад зүйл заалттай зөрчилдөхгүй байх ёстой. Эцэст нь дүгнэхэд, хуульд байцаан шийтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх стандартыг тусгах хэрэгтэй.

III. СОНГУУЛИЙН МАРГААНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ СТАНДАРТ СИСТЕМ

Энэ бүлэгт сонгуулийн маргааны хяналт шинжилгээний стандарт системийг тайлбарлах ба үүнд дараархь бүрэлдэхүүн хэсгүүд багтдаг.

- Сонгуулийн маргаан шийдвэрлэх схем: үүнд сонгуулийн маргааныг шийдвэрлэдэг сонгуулийн тухай хуулиас гадуурх эрх зүйн заалтуудыг зураглах зорилготой.
- Шийдвэрлэсэн байдлаар нь гомдол, давж заалдах нэхэмжлэлийг тандаж судлахад ашигладаг мэдээллийн сан
- Сонгуулийн маргааны дүн шинжилгээний матриц: үүнд мэдээллийн бааз хариулт өгөх боломжтой асуултын жагсаалтаас бүрдэх ба тухайн улс орон дахь сонгуулийн маргааны хандлагыг илэрхийлэхэд ашиглах боломжтой.
- Сонгууль ажиглах багийн хүрээнд сонгуулийн маргаан хянаж шинжлэх багт зориулсан бүтэц зохион байгуулалтын схем
- Урт хугацааны ажиглагчид болон санал дүгнэлтийн удирдамж г.м.

A. Сонгуулийн маргаан шийдвэрлэх схем

Сонгуулийн маргаан шийдвэрлэх схемийн бүтцийг хүснэгт форматаар доор тусгав.

1 Үйл ажиллагаа	2 Сонгуультай холбоотой зөрчлүүд	3 Эрх зүйн заалт	4 Нэхэмжлэгч	5 Хэн гомдол гаргах	6 Хаана	7 Гомдол гаргах эцсийн хугацаа	8 Гомдол хянаж үзэх хугацаа	9 Давж заалдах	10 Ял шийтгэл

- 1 ба 2-р баганад хуульд заагаагүй төрөл хэлбэрийг тайлбарлах
- 3-р баганад хуулинд тусгагдсан сонгуультай холбоотой зөрчил, үйл ажиллагаа, гэмт үйлдлийн жагсаалтыг тусгах
- 4-р баганад буруутай байж болзошгүй хүн, байгууллагыг бичих
- 5-р баганад сонирхогч талуудыг тусгах
- 6-р баганад зөрчил шүүн таслах эрх мэдэлтэй талуудыг тусгах
- 7, 8-р баганад хуулиар тогтоосон хугацааг тусгах
- 9-р баганад аливаа тал давж заалдах боломжийг тайлбарлах
- 10-р баганад буруутай шийдвэрийн үр дүнг хэрэгжүүлж сахиулах ямар механизмууд байгааг тусгана.

Сонгуулийн явцын дарааллыг харуулахын тулд хүснэгтийг дараахь байдлаар хуваана.

А. Сонгуулийн өмнөх бүртгэл	
Б. Сонгуулийн сурталчилгаа	
В. Сонгуулийн/санал хураалтын өдрийн асуудлууд	
Г. Санал өгсний дараахь асуудлууд	
Д. Ерөнхий асуудлууд	

Эрх зүйн системүүд нь сонгуулийн маргаан шийдвэрлэх цөм зарчмуудыг баримтлахад шаардлагатай заалтуудыг тусгасан эсэхийг энэхүү схемээр амархан үнэлэх боломжтой. Тухайлбал, давж заалдах заалтууд байхгүй нөхцөлд ЕАБХАБ-ийн өмнө хүлээсэн гишүүн улс орны үүрэг хариуцлагыг зөрчиж байна гэсэн үг юм. Эс бөгөөс ял шийтгэл байхгүй нөхцөлд буруутай гэж үзсэн шийдвэрийн дагуу авах арга хэмжээний хэрэгжилтийг хянаж шинжлэх хэрэгтэй. Эцэст нь сонгуулийн хороод, шүүх, бусад байгууллагууд нь хуулийн заалтуудыг хэрэгжүүлэн, сахиулж буй эсэх нь тусдаа асуудал бөгөөд гаргасан шийдвэр, авсан арга хэмжээг шинжлэх замаар зөвхөн үнэлж дүгнэх боломжтой. Гэхдээ энэхүү схем нь сонгуулийн маргаан шийдвэрлэх эрх зүйн тогтолцооны чадавхийг үнэлэх стратеги бүрдүүлэхэд тус дөхөм болох боломжтой. Сонгуулийн хуулийг зөрчсөн зөрчлүүдтэй шууд холбогдох ял шийтгэл байхгүй тул, ихэнх тохиолдолд сонгуулийн хуулиудыг хойш нь тавьж, оронд нь эрүүгийн хууль буюу эрүүгийн байцаан шийтгэх хууль зэрэг хуулиад дахь заалтуудыг ашиглах талтай. Сонгууль ажиглагчдын багт эдгээр заалтын орчуулагдсан хувилбар тэр болгон олддоггүй тул, уг схемийг хялбар зөвлөлгөөний зорилгоор боловсруулсан. Гэвч хянаж нягтлах гол заалтууд нь тухайн орны хууль тогтоомжийн дагуу харилцан адилгүй байна. Цаашилбал, уг схем нь ярвигтай байж болох ч, сонгуулийн жинхэнэ маргааныг аль болохоор цогц схемтэй шинжлэх нь чухал юм.

Б. Сонгуулийн маргааны мэдээллийн сан

Энэ бүлгийн эхний “А” хэсэгт цуглуулсан мэдээллийг ангилах, зохион байгуулах арга зүй, мөн гомдлын шийдвэрүүдэд тулгуурлан гомдлыг тандан судлах арга зүйг тусгасан билээ. Харин энэ хэсэгт сонгуулийн маргааны мэдээллийн санг боловсруулах практик асуудлуудыг авч үзнэ.

Хамгийн түрүүнд ихэнх тохиолдолд мэдээллийн сан нь эрх бүх байгууллагад гаргасан гомдол саналаар хязгаарлагдах бөгөөд тэдгээр гомдолд дурдсан зөрчлүүдтэй холбоотой баримт нотолгооны хуулбарыг сонгууль ажиглагчид хүлээн авчээ.

Энэ аргачлалыг авч үзсэн 4 гол шалтгаан:

- Нэгдүгээрт, сонгуулийн маргаан шийдвэрлэх эрх зүйн систем болон эрх зүйн дүйцүүлэх механизмуудын аль алины үр ашгийг хянаж нягтлахын тулд зөрчил арилгахыг хүсч шаардсан гомдлуудыг зөвхөн авч үзнэ.
- Хоёрдугаарт, нэхэмлэгч буюу эрх бүхий байгууллагууд нь тухайн зөрчлийн үнэ бодит байдлыг тогтоох боломжтой тул, дүгнэлт гаргахын тулд уг мэдээ мэдээллийг ашиглах нөхцөлд гомдол гаргасан тухайн үйл явдал буюу зөрчлийн тухай баримт шаардлагатай болно.
- Гуравдугаарт, бодит нотолгоо нь гомдлын зөрчлийг шалгах, нягтлах ажлыг хөнгөвчилдөг.
- Дөрөвдүгээрт, энэхүү стратегийн зорилго нь нотлогдоогүй гомдлыг арилгах, сонгуулийн үйл явц болон гомдол саналыг хянаж шинжлэх Сонгуулийн ажиглагчдын хязгаарлагдмал нөөц боломжийн үр ашгийг нэмэгдүүлэхэд оршино.

Гэвч энэ арга зүйд нэг дутагдал бий. Хүмүүс (ноцтой зөрчлийн боломжит хүчин зүйлс болохуйц) нэрс буюу баримт бичгийг гаргаж өгөхөөс айж эмээсэн буюу хүсэхгүй байгаа тохиолдолд, уг зөрчлийг мэдээллийн санд бүртгэхгүй. Сонгуулийн маргааны мэдээллийн санд ашигладаг чиглэлүүдийг дор тайлбарлав. (ө.х. гомдлын өргөдлийг бүртгэхэд бөглөх талбарууд). Мэдээллийн сангийн зорилго нь тухайн улс орны сонгуультай холбоотой маргааны тоо хэмжээ болон холбогдох эрх зүйн болон сонгуулийн тогтолцооны маргаан шийдвэрлэх үйл явцын талаарх мэдээлэл цуглуулахад оршино. Мэдээ мэдээлэл нь эрх зүйн, сэдэвчилсэн, газар зүйн болон бусад хэв шинжид хийх дүн шинжилгээг хөнгөвчлөн хялбарчилж өгнө.

Дугаар/код: Сонгуулийн ажиглалтын хүрээнд хүлээн авсан хэрэг буюу гомдол бүрийг таньж мэдэхийн тулд бүртгэгдсэн хэрэг буюу гомдол тус бүрийг тоогоор дугаарлана. Энэхүү дугаар нь зохион байгуулалтын зөвхөн зорилготой тул үүнийг шүүхэд хандсан хэргүүдийн тоо, шийдвэрийн тоо, арга хэмжээ авахуулахаар төрийн байгууллагад шилжүүлсэн хэргийн тоо зэрэгтэй андуурч болохгүй.

Шүүх/Сонгуулийн Хороо/бусад байгууллага: Энэ талбарт гомдол хүлээж авдаг төрийн байгууллагыг бичнэ. Шүүхийн байгууллагууд маргаан, гомдлыг ерөнхийдөө шийдвэрлэх боловч, сонгуулийн үеэр сонгуулийн хороод зэрэг бусад байгууллагуудад сонгуулийн

маргааныг шийдвэрлэх эрх мэдэл олгох тухай тусгай заалтууд байдаг. Бусад байгууллага гэдэгт яамд, тугай шүүх, олон нийтийн прокурор багтаж болно. Энэ талбар нь гомдол гаргагчдын хүсэлт гаргасан асуудлуудыг ойлгоход тус дөхөм үзүүлэх боломжтой.

Огноо: Энэ талбарт тухайн хэргийн бүртгэлийн маягтад тусгаснаар уг хэргийн талаарх гомдлыг төрийн байгууллагад гаргасан огноог бичих бөгөөд харин сонгууль ажиглагчдын анхааралд өртсөн буюу бүртгүүлсэн огноог илтгэхгүй болно. Өмнө дурдсанчлан, зөрчлийг арилгуулахаар хүсэлт гаргасан гомдлыг зөвхөн бүртгэх ёстой. Тухайн гомдол гаргасан огноог оруулснаар шүүх буюу сонгуулийн хороодын арга хэмжээний үргэлжлэх хугацаа хэтэрсэн эсэхийг үнэлж дүгнэх боломж бүрдэнэ. (хүснэгтийг үзнэ үү)

Бүс нутаг: Энэ талбарт тухайн улсын сонгуулийн удирдлагын дэд салбар/хэсгийг тусгах (ө.х. сонгуулийн тойрог, дүүрэг г.м.) ба улс орон бүрт харилцан адилгүй байна. Гэвч сонгуультай холбоотой зөрчлүүдийг ойлгож мэдэх, гол зөрчил гардаг чиглэл/асуудлыг хянаж шинжлэх нь нэн чухал ач холбогдолтой. Энэ талбар нь сонгуулийн ажиглагчдад сонгуулийн явцад гомдол маргааныг газар зүйн хэв шинжээр тэмдэглэх боломж олгоно.

Сонгуулийн тойрог/дүүрэг: Энэ талбарт тухайн сонгуультай холбоотой сонгуулийн удирдлага захиргааны нэгжийг бичнэ. Энэ талбарт бичих мэдээлэл нь сонгуулийн удирдлагын зөрчлүүд, санал өгөх болон тоолох явцад гарсан зөрчлүүдийг хянаж шинжлэхэд маш чухал ач холбогдолтой.

Гомдол гаргагч: Энэ талбарт эрх нь зөрчигдсэн гэх иргэн ба байгууллагын нэрийг бичнэ. Шүүхэд хандсан хэргүүдэд энэ нь нэхэмжлэгч талд хамаарах бөгөөд сонгуульд ихэвчлэн нэр дэвшигчид гомдол гаргах нь түгээмэл байдаг. Нэр дэвшигчид нь сонгуулийн явцад ихэвчлэн гомдол гаргадаг тул, тэднийг төлөөлж нам, бүлэг гомдол гаргасан байсан ч, нэр дэвшигчийн нэрийг энэ талбарт бичиж оруулбал зохино.

Буруутгагдсан буюу зөрчил гаргасан субъект: Энэ талбарт тухайн гомдолд буруутай/зөрчил гаргасан гэгдэж буй байгууллага, хувь хүний талаарх мэдээллийг бичнэ. Сонгуулийн явцад ихэвчлэн буруутгагддаг талуудад сонгуулийн хороод, бусад нэр дэвшигчид, төрийн болон бусад байгууллагууд хамаардаг.

Тойм дүгнэлт: Энэ хэсэгт гомдолд тусгагдсан зөрчил/фактын талаар дэлгэрэнгүй тайлбарыг тусгана. Энэ мэдээлэл нь аль болохоор дэлгэрэнгүй, мөн товч богино ч байж болно.

Статус: Энэ талбарт тухайн хэргийг анх хандаж хүргүүлсэн байгууллагын шийдвэр, арга хэмжээний дараа давж заалдсан буюу өөр газарт шилжүүлсэн эсэхийг бичнэ. Тухайлбал, тухайн гомдол/хэргийг засгийн газрын нэг хэлтэс нэгжид хүргүүлсний дараа тухайн субъект нь өөр газар, үүнд прокурор, сонгуулийн ерөнхий хороо, эсвэл шүүхэд шилжүүлсэн байж болно.

Энэ аргачлалын үндэслэл нь эрх зүйн системийн үр ашгийг тандан судлахын тулд намуудын хэргүүдээ танилцуулах чадварыг онцлон үзэх хэрэгтэй. Цаашилбал сонгуулийн маргаан хянаж шинжлэхийг хүсч буй сонгуулийн ажиглагчдын хувьд шүүхийн дүгнэлт чухал бөгөөд бусад эрх зүйн дүгнэлт нь үүнийг эргэлзээтэй болгож магадгүй.

Тайлбар: Сонирхол татахуйц бусад бүх мэдээллийг энд бичнэ. Тухайлбал, ижил гомдлууд байвал, мөн бусад талбарт хамааралгүй мэдээлэл байвал энэ хэсэгт дурдаж болно. Сонгуулийн маргаан шийдвэрлэх үрдүнг хянаж шинжлэх боломжийг Сонгууль ажиглагчдад бүрдүүлэхийн тулд, шийдвэрүүдийн эрх зүй, шүүх, хууль сахиулах үндэслэлийг холбогдох талбарт тусгах нь нэн чухал болно.

Гомдлын эрх зүйн үндэслэл: Гомдолд тусгагдсан зөрчлийг энд бичнэ. Энэ талбарт нь гомдол гаргагчийн өөрийн үндэслэлийг тусгах бөгөөд харин гомдлыг бүртгэгчийн үзэж ойлгож буй үндэслэлийг бичихгүй. Тухайлбал гомдол гаргагч нь аливаа эрх зүйн үндэслэл (ө.х. зөрчсөн гэж үзэж буй хууль буюу зүйл заалт) тусгаагүй байвал уг талбарыг хоосон үлдээнэ.

Шийдвэр: Шүүх, сонгуулийн хороод, бусад байгууллагын гаргасан шийдвэрийг энд бичнэ. Тухайн шийдвэрийн эрх зүйн үндэслэл (үндэсний хууль, дүрэм код, зүйл заалт)-ийг тодорхой тусгана.

Хууль сахиулах: Шийдвэрийг хэрэгжүүлсэн эсэх? Хэзээ, хэрхэн хэрэгжүүлсэн эсэх? Зөрчил арилгасан арга хэмжээ нь нэхэмжлэгч/гомдол гаргагч талд хангалттай байсан уу? Арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн эсэх? Гомдол гаргагчийг ангилах ангиллын систем боловсруулах нь цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд суурь ач холбогдолтой. Ангиллын төрөл хэлбэр нь хэт ярвигтай байх ёсгүй бөгөөд тухайн улс орон, сонгуулиас шалгаалан харилцан адилгүй төрөл хэлбэр шаардагдаж болох хэдий ч, сонгуулийн маргааны үндсэн ангиллыг дагаж баримтлах нь олон улсын түвшний болон бүс нутгийн хандлагын дүн шинжилгээ хийх боломж олгоно.

Ангилал: Тухайн сонгуулийн хүрээнд гомдол гаргачдын анхаарч буй чиглэлүүд, эрх зүйн доголдол хаана байгааг тодорхойлоход гомдлын ангиллын систем тусална. Тухайн ангиллын төрлүүдэд хамаарах хэргүүдийн агуулгыг нарийвчлан шинжилснээр хууль буюу түүний хэрэгжилттэй холбоотой сул талуудыг илрүүлэх боломжтой. Тухайлбал сурталчилгааны саад бэрхшээлийн талаарх гомдол/хэргийг нарийвчлан шинжилсний үр дүнд төр засгаас авч буй арга хэмжээ нь гомдол гарах гол шалтгаан болж буйг тодорхойлж болох юм.

V. Сонгуулийн маргааны дүн шинжилгээний матриц

1. Үндсэн мэдээлэл хайх

“Үндсэн мэдээлэл хайх” гэсэн ангилалд хамаарах ерөнхий багц асуултуудыг мэдээллийн сангаас хялбар хайлтаар татаж авах боломжтой. Сонгуультай холбоотой гомдлын статусын урьдчилсан мэдээлэл авахын тулд энэхүү хэсгийг холбогдох асуултуудын төрлүүдэд цааш задалж хуваана. “Ерөнхий мэдээлэл”, “гомдол, нэхэмжлэлийн ангилал”, “сонгуулийн маргаан шийдвэрлэх эрх бүхий байгууллага” зэрэг категорт хуваагдана. “Ерөнхий мэдээлэл” гэсэн хэсэгт сонгууль ажиглах томилолтын явцад цуглуулсан

мэдээллийн товч тоймыг оруулбал зохино. Маргааны ангиллын системд тулгуурлан ажиглагчид тухайн сонгуулийн сул талуудыг тодорхойлох боломжтойн зэрэгцээ гомдол хүлээн авагч байгууллагуудын задаргаа нь зөрчил арилгах боломжит сувгуудыг тодорхой болгоход дөхөм үзүүлнэ. Нарийвчилсан дүн шинжилгээ хийж сонгуулийн маргаан шийдвэрлэх эрх зүйн системийн давуу ба сул талуудыг илрүүлэх боломжийг энэ хэсэгт хамаарах асуултууд бүрдүүлнэ.

а) Ерөнхий мэдээлэл

1. Сонгууль ажиглагчдын багийн анхааралд хэдэн гомдол/хэрэг ирсэн бэ?
2. Эдгээр гомдол/хэргээс хэдэн гомдлыг шийдвэрлэсэн бэ?
3. Эдгээр шийдвэрээс хэдийн хэрэгжүүлсэн бэ?
4. Хэн гомдол гаргасан бэ? (гомдол гаргагчдын талаар дэлгэрэнгүй мэдээлэл бичих)
5. Гомдлын газар зүйн/нутаг дэвсгэрийн харъяалал (бүс, дүүрэг, тойрог)?
6. Гомдол/давж заалдах нэхэмжлэлийн дагуу шийдвэр гаргасан газар зүйн/нутаг дэвсгэрийн харъяалал?
7. Хариуцагч тал нь хэн болох?

б) Гомдлын категорууд

8. Сонгуулийн сурталчилгаатай холбоотой хэрэг гомдол/хэрэг ирсэн бэ? (Хууль бус сурталчилгаа, сурталчилгаатай холбоотой бэрхшээлийн талаарх гомдол/хэргийн нийт тоог тусгах. Мөн сонгуулийн хороод болон шүүхэд хамаарах хэргүүдийг тодорхой ялгаж зааглах)
9. Хууль бус сурталчилгаатай холбоотой хэдэн хэрэг байна вэ? (сонгуулийн хороод болон шүүхэд хамаарах эсэхийг ялгах)
10. Сонгуулийн саад бэрхшээлтэй холбоотой хэдэн хэрэг байна вэ? (сонгуулийн хороод болон шүүхэд холбогдох эсэхийг ялгах)
11. Нэр дэвшигчдийн бүртгэлтэй холбоотой хэдэн хэрэг байна вэ? (сонгуулийн хороод болон шүүхэд хамаарах эсэхийг ялгах)
12. Санал өгөх өдөртэй холбоотой хэдэн хэрэг байна вэ? (Санал өгөх, тоолохтой холбоотой хэргүүд? Мөн сонгуулийн хороод болон шүүхэд хамаарах эсэхийг ялгах)
13. Санал өгөх үйл явцтай холбоотой хэдэн хэрэг байна вэ? (сонгуулийн хороод болон

шүүхэд хамаарах эсэхийг ялгах)

14. Санал тоолох үйл явцтай холботой хэдэн хэрэг байна вэ? (сонгуулийн хороод болон шүүхэд хамаарах эсэхийг ялгах)

15. Сонгуулийн удирдлагатай холбоотой хэдэн хэрэг байна вэ? (сонгуулийн хороод болон шүүхэд хамаарах эсэхийг ялгах)

16. Нэр төрд халдсан гэх хэдэн хэрэг байна вэ? (сонгуулийн хороод болон шүүхэд хамаарах эсэхийг ялгах)

в) Сонгуулийн маргаан шийдвэрлэх эрх бүхий байгууллагууд

Сонгуулийн хороод

17. Сонгуулийн хороодод хандаж хэдэн хэрэг ирүүлсэн бэ? (сонгуулийн хороод болон шүүхэд хамаарах эсэхийг ялгах)

18. Сонгуулийн хороод хэдэн хэрэг шийдвэрлэсэн бэ? (сонгуулийн хороод болон шүүхэд хамаарах эсэхийг ялгах)

19. Хуулиар тогтоосон хугацааны дотор эдгээр шийдвэрүүдийг гаргасан уу? (шийдвэрлэх ёстой хуулийн хугацааг хэтрүүлсэн хэргүүдийн хувьд шалтгааныг тайлбарлах. гомдлын хамаарах ангиллын төрлийг тусгах)

20. Сонгуулийн хороодын гаргасан хэдэн шийдвэрийг хэрэгжүүлсэн бэ? (гомдлын хамаарах ангиллын төрлийг тодорхой тусгах)

Шүүх

21. Шүүхэд хандаж хэдэн гомдол/хэрэг ирүүлсэн бэ? (гомдлын хамаарах ангиллын төрлийг тодорхой тусгах)

22. Шүүхэд хандсан хэргүүдийн хэдийг шийдвэрлэсэн бэ? (гомдлын хамаарах ангиллын төрлийг тодорхой тусгах)

23. Хуулиар тогтоосон хугацааны дотор эдгээр шийдвэрүүдийг гаргасан уу? (шийдвэрлэх ёстой хуулийн хугацааг хэтрүүлсэн хэргүүдийн хувьд шалтгааныг тайлбарлах. гомдлын хамаарах ангиллын төрлийг тусгах)

24. Шүүхээс гаргасан хэдэн шийдвэрийг хэрэгжүүлсэн бэ? (гомдлын хамаарах ангиллын төрлийг тодорхой тусгах)

Энэ асуултын хариулт нь "сонгуулийн маргаан шийдэх эрх бүхий байгууллагууд" хэсэгт тусгагдсан буй.

Прокурор

25. Прокурорт хандаж хэдэн гомдол/хэрэг ирүүлсэн бэ? (гомдлын хамаарах ангиллын төрлийг тодорхой тусгах)

26. Прокурорт хандаж ирүүлсэн хэргүүдийн хэдийг шийдвэрлэсэн бэ? (гомдлын хамаарах ангиллын төрлийг тодорхой тусгах)

27. Хуулиар тогтоосон хугацааны дотор эдгээр шийдвэрүүдийг гаргасан уу? (шийдвэрлэх ёстой хуулийн хугацааг хэтрүүлсэн хэргүүдийн хувьд шалтгааныг тайлбарлах. гомдлын хамаарах ангиллын төрлийг тусгах)

28. Прокурорын гаргасан хэдэн шийдвэрийг хэрэгжүүлсэн бэ? (гомдлын хамаарах ангиллын төрлийг тодорхой тусгах)

2. Сонгуулийн маргаан шийдвэрлэх сувгуудын нарийвчилсан дүн шинжилгээ

Мэдээллийн сангаас татсан үндсэн мэдээлэл тулгуурлан, гүнзгийрүүлсэн дүн шинжилгээ хийх замаар маргаан шийдвэрлэх механизмын үр дүн, үр ашигтай ажиллагааг тодорхойлох боломжтой. Дүн шинжилгээ нь улс орон бүрт сонгуулийн төрлөөс хамааран тодорхой хэмжээгээр харилцан адилгүй байна. Гэвч ихэнх улс оронд эдгээр асуултын хариулт нь ойлгож шинжлэхэд маш түвэгтэй байдаг бөгөөд тухайн хэргүүдийн шийдвэр, баримт бичгүүдийг шинжлэх шаардлага гарна.

Доор дүн шинжилгээний асуултуудыг тусгасан ба хариулт авсан нөхцөлд тухайн эрх зүйн системийг үнэлэх эрх зүйн чадавх дээшилж, зөвлөмжийн нийцэмж/чанар сайжирна.

Дүн шинжилгээний асуултууд: нарийвчилсан мөргөн шалгалт хийх шаардлагатай хэргүүд

29. Хэдэн хэргийг цааш нарийвлан мөрдөн шалгах шаардлагатай гэж үзсэн бэ? (гомдлын хамаарах ангиллын төрлийг тодорхой тусгах)

30. Сонгуулийн хороодоос хэдэн хэргийг хууль сахиулах агентлагууд буюу төр засгийн бусад байгууллагууд руу шилжүүлсэн бэ? (гомдлын хамаарах ангиллын төрлийг тодорхой тусгах)

31. Нарийвчилсан мөрдөн шалгалт шаардлагатай хэргүүдээс хэдэн хэргийг прокурорт шилжүүлсэн бэ? (гомдлын хамаарах ангиллын төрлийг тодорхой тусгах)

32. Эдгээр хэргээс хэдэн хэргийг шийдвэрлэсэн бэ? (гомдлын хамаарах ангиллын төрлийг тодорхой тусгах)

33. Сонгуулийн хороодын гаргасан шийдвэрүүдийн бодит үндэслэл юу болох?

34. Шүүхийн шат бүрт гаргасан шийдвэрийн бодит үндэслэл юу болох?
35. Шийдвэрүүдийн хэрэгжилтийн түвшин, үр дүнгийн талаар байгууллага/ институцийн хооронд ялгаа байгаа эсэх?
36. Давж заалдах нэхэмжлэлийн бодит үндэслэл юу болох? (ялангуяа прокурортой холбоотой)
37. Тухайн институцийн тогтолцоонд гаргасан гомдол/хэргийн нийт тоохэмжээний талаарх ямар статистик байгаа эсэх? (сонгуулийн ажиглагчдын анхааралд ирсэн хэргүүдийн үндэслэлийг үнэлэхийн тулд)
38. Сонгуулийн удирдлагатай шууд холбоотой хэдэн хэрэг байгаа эсэх, эрх зүйн ба сонгуулийн тогтолцооны бүтцийн сул талуудад холбогдох хэдэн хэрэг байгаа эсэх?

Г. Сонгуулийн маргаан шийдвэрлэх монитохиргын багт зориулсан зохион байгуулалтын схем

Сонгуулийн маргааны хяналт шинжилгээ нь сонгууль ажиглалтын салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд сонгууль ажиглах явцад уялдуулбал зохино. Эрх зүйн системийн сонгуулийн маргаан шийдвэрлэх үр дүнтэй байдлын үнэлгээ нь тухайн улс орны хууль дээдлэх ёсын ерөнхий төлөв байдлыг илтгэх тул, сонгуулийн маргааны мониторинг нь сонгуулийн ажиглалтыг хүний эрх болон ардчиллыг хөгжүүлэх бусад төслүүдтэй холбож уялдуулахад тус дөхөм үзүүлэх боломжтой.

Сонгуулийн маргааны хяналт шинжилгээг эрх зүйн зөвлөх ахлах нь зүйтэй бөгөөд тэрбээр (i) сонгуулийн хороод буюу удирдлагатай хамтран ажиллах үүрэгтэй сонгуулийн эксперт, мөн (ii) урт хугацааны ажиглагчид (LTOs)-ыг уялдуулан зохицуулах үүрэгтэй эксперт нартай аль болох ойр нягт хамтран ажиллана. Сонгуулийн хороод болон шүүхийн үүрэг роль ялгаатай хэдий ч, тус хоёр субъект нь хамтын ажиллагаа биш гэхэд харилцан үйл ажиллагаагаа шаардлагатай чиглэлүүдээр уялдуулан зохицуулж ажиллах шаардлагатай.

Дэлхийн улс орнуудад эрх зүйн тогтолцоо нь харилцан адилгүй байх тул, орон нутгийн шүүгчдээс туслалцаа авах нь нэн чухал юм. Тухайн улсын цар хэмжээ, хүн амын тоо, шүүх эрх мэдлийн тогтолцоо (ө.х. тусдаа дүрэм, журамтай автономит эрхтэй муж улсууд г.м.), сонгуулийн төрөл зэрэг олон хүчин зүйлсээс шалтгаалан орон нутгийн шүүгчдийн тоо харилцан адилгүй байдаг. Эрх зүйн эксперт нь олон улсын хамтын нийгэмлэгийг төлөөлөх тул, эрх зүйн зөвлөх (гадаадын мэргэжилтэн) нь тухайн улсын хэлний мэдлэг сайн байсан ч, орон нутгийн шүүгчид нь орон нутгийн мэдээ үзэж танилцах талаар нэлээд туршлагатай байдаг.

Урт хугацааны ажиглагчид сонгуулийн маргааны мониторинг хийх нь хамгийн оновчтой байдаг. Урт хугацааны ажиглагчид нь сонгуулийн маргааны талаар мэдээлэл цуглуулахад

илүү тохиромжтой бөгөөд тэд компьютерээр хангагдсан байсан ч мэдээ мэдээллийг мэдээллийн санд шууд хийх боломжтой. Эс бөгөөс гомдлын бүртгэлийг орон нутгийн шүүгчид, эрх зүйн зөвлөх хийх шаардлагатай. Бүс нутгийн түвшинд сонгуулийн маргааныг Урт хугацааны ажиглагчид хянаж шинжлэн, бүртгэх боломжтой нөхцөлд, төв оффисын ажилтнууд нь дараахь үүрэг даалгаварт анхаарах боломжтой.

- үндэсний түвшин дэх сонгуулийн маргааны мониторинг
- сонгуулийн маргаантай шууд холбоотой эрх зүйн судалгаа
- сонгуулийн маргааны хэв шинжийн дүн шинжилгээ г.м.

Урт хугацааны ажиглагчид нь орон нутгийн маргааныг хянаж шинжлэхэд хамгийн оновчтойн зэрэгцээ төв оффис нь үндэсний түвшний хэрэг, шийдвэрүүдийг хялбар ажиглах боломжтой. Үүнд дээд шатлалын шүүх, сонгуулийн хороодод ирсэн сонгуулийн маргаанууд хамаарна. Сонгуулийн маргааны талаарх эрх зүйн судалгааны хүрээнд үндэсний түвшинд сонгуулийн хууль тогтоомжийг зохистой ашиглаж, хэрэгжүүлж байгаа эсэхийг үнэлж дүгнэх хэрэгтэй. (ө.х. улс орон даяарх шүүх байгууллагууд ижил төстэй дүгнэлтүүд гаргаж буй эсэх, сонгуулийн хуулийг янз бүрээр хөрвүүлж буй эсэх? г.м.). Эцэст нь сонгуулийн маргааны хэв шинжийн дүн шинжилгээнд улс орон даяар цуглуулсан мэдээллийн ерөнхий тоймыг хамруулах хэрэгтэй.

Д. Урт хугацааны ажиглагчдын удирдамж, тайлбар

Сонгуулийн ажиглалтын хүрээнд сонгуулийн хугацаанд ашиглагдах маргаан шийдвэрлэх механизмуудыг ихэвчлэн авч үздэг ч, сонгуулийн маргааны талаар системтэй, цогц аргачлал ашиглах нь сонгуулийн ажиглалтад эерэг ач холбогдолтой бөгөөд сонгуулийн үйл явцын болон сонгууль явагдаж буй эрх зүйн системийн сул талуудыг илрүүлж тодруулах боломжтой. Цаашилбал, сонгуулийн маргааны талаар мэдээлэл цуглуулах дараахь удирдамжийг боловсруулав. Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллагын Ардчилал, хүний эрхийн алба (OSCE/ODIHR)-наас гаргасан Сонгууль ажиглах гарын авлага -д тусгасан ёс зүйн дүрмээс гадна сонгуулийн маргааныг хянаж шинжилж буй ажиглагчид нь дараахь дүрмийг дагаж мөрдөнө.

1. Гомдлын талаарх мэдээлэл цуглуулах ёс зүйн дүрэм

- Гомдол гаргагчтай ярилцах явцад сонгуулийн ажиглалт нь тухайн гомдол, маргаанд нөлөөлөх буюу шийдвэрлэх эрх мэдэл байхгүй болохыг заавал сануулж мэдээлэх. Гэвч сонгуультай холбоотой гомдлыг хянаж шинжлэх, тандан судлах нь сонгууль ажиглах ажлын нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд төр засгийн удирдлагын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх боломжтой.
- Гомдол гаргагчдыг нууцлах, хамгаалах нь нэн тэргүүний зорилт асуудал болно.
- Аль болохоор бодитой байх. Оролцогч бүх талтай холбоо барьж, ярилцах (ө.х. гомдол гаргагч, хариуцагч тал, шүүн таслах эрх бүхий субъект г.м.)
- Гомдлын талаарх уулзалтыг аль болохоор 2 ажиглагч байлцуулж хийх.

Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллагын Ардчилал, хүний эрхийн алба (OSCE/ODIHR)-наас гаргасан Сонгууль ажиглах гарын авлага , 4 дэх хэвлэл, 1999 оны 4-р сар, Варшав хот.

- Аль нэг байгууллагад гаргасан гомдлын тухайд, аль болохоор баримт бичгийн хуулбарыг олж авах

- Сонгуулийн хороо буюу шүүх нь сонгуулийн маргааны талаар сонсгол зохион байгуулах нөхцөлд аль болохоор оролцохыг хичээх боловч, олон нийтэд нээлттэй сонсгол байсан ч урьдчилж зөвшөөрөл авах. Зөвшөөрөл авахаар хандах хүн нь ихэвчлэн ерөнхий шүүгч буюу сонсгол даргалагч байна. Сонсгол дээр талуудад хандаж үг хэлж болохгүй ба учир нь та төвийг сахисан ажиглагч гэдгийг мартаж өсгүй.

2. Бүрэн гүйцэд мэдээлэл цуглуулах

Асуух асуултын төрөл хэлбэр, цуглуулах мэдээллийг дараахь байдлаар тоймлох боломжтой.

- Хэн: Оролцогч бүх хүмүүсийн нэрс, харъяалал, чиг үүрэг, холбоо барих дэлгэрэнгүй хаяг. Хэн гомдол гаргаж буй эсэх? (жишээлбэл: сонгогчид, нэр дэвшигч, намын төлөөлөгч г.м.) Хэн уг зөрчлийг гаргасан эсэх? (жишээлбэл: бусад нам, орон нутгийн удирдлага эсвэл бусад эрх бүхий субъект, хэвлэл мэдээлэл г.м.)

- Юу болсон: Тухайн асуудлын бодит цаг хугацааны талаар дэлгэрэнгүй тэмдэглэл хийх. Аль болох тодорхой мэдээлэл асуух (ө.х. нэрс, бодит газар/байршил, огноо, гэрч г.м.). баримт бичиг, видео, сонингийн нийтлэлийн хуулбар зэрэг бодит нотолгоо байгаа эсэхийг тодорхойлох, олж авах

- Хаана: Уг гомдлын хаана гаргасан эсэх? Шүүхэд үү, эсвэл Сонгуулийн Хороонд уу? (өөр эх сурвалж байгаа эсэх?) Гомдлын талаар сонссон эх сурвалжийг дурдах. Гомдлыг шүүх буюу сонгуулийн хороонд гаргасан бол, уг гомдлыг шийдэж буй шүүх буюу сонгуулийн хорооны олгосон тухайн хэргийн дугаарыг асуух.

Сонгуулийн маргааны хяналт шинжилгээнд баримтжуулсан хэргүүдийг чухалчилдаг ч, гомдлын талаарх ерөнхий мэдээлэл хоёр шалтгаанаар ач холбогдолтой. Нэгдүгээрт, ерөнхий мэдээлэл нь гомдлын талаар товч тойм бүрдүүлэх бөгөөд хоёрдугаарт, мэдээлэгдсэн боловч нотлогдоогүй гомдлыг дараа нь аль нэг байгууллагад хандан албан ёсоор гаргаж болох талтай.

Хэргийн үйл явдал болон оролцогч хүмүүсийн дэлгэрэнгүй мэдээллээс гадна, эрх зүйн зөвлөхийн хувьд цуглуулсан мэдээлийн үнэ цэн нь тухайн эрх зүйн системийн маргаан шийдвэрлэх үйл явцын талаарх мэдээлэл нь хэр зэрэг бүрэн гүйцэд эсэхээс ихээхэн шалтгаална. Үүнийг хангахын тулд дараахь гурван үе шатыг байнга санаж, үе шат бүрт холбогдох мэдээлэл цуглуулна.

Эрх зүйн лавлагаа ба үр дүн

1. Эрх зүйн зүйл заалтууд: Тухайн зөрчилтэй үйлдлийн талаар ямар хуульд тусгасан

эсэх? Ямар холбогдох тогтоол шийдвэр, зохицуулалт байгаа эсэх? (сонгуулийн ба сурталчилгааны хуульд голчлон анхаарах боловч, бусад холбогдох хууль тогтоомжийг авч үзэх)

2. Шүүн таслах (шийдвэр): Шийдвэр гаргасан эсэх? Ямар эрх үүрэгтэй хэн/аль субъект шийдвэр гаргасан эсэх? Тус хэргийг давж заалдах уу? Захиргаа арга хэмжээ авсан эсэх? Тухайн шийдвэрийн огноо, хуулбар байгаа эсэх?

3. Хууль сахиулах: Шийдвэрийг хэрэгжүүлсэн эсэх? Хэн хэрэгжүүлсэн эсэх? (хариуцагч тал уу? төрийн байгууллага уу? Энэ нь хангалттай эсэх?).